

☆☆YNU Campus Tour map☆☆



Nishoku – Хоолны хоёрдугаар танхим

Нишोकү гэдэг нь “Хоолны хоёрдугаар танхим” гэсэн утгатай. “Ни” гэдэг нь японоор хоёр гэсэнүг бөгөөд харин “Шокү” гэдэг нь “Шокүдо” буюу хоолны газар гэсэн үгний товчлол юм. Хоёрдугаар хоолны танхим нь инженерийн факультэттэй ойр тул ихэвчлэн инженерийн оюутнууд ордог. Хоолны сонголтын хувьд их өргөн бөгөөд Япон маягийн хоолноос эхлээд Европ маягийн хоол хүртэл бий. Үнийн хувьд ч гэсэн их боломжийн бөгөөд хоолоо сэтээр нь эсвэл өөрөө хүссэнээрээ сонгон авч идэх боломжтой.



Meikyo -shizen monument-Мэйкёо хөшөө

Энэхүү хөшөөн дээр “Мэйкёо Шизэн” гэж бичээстэй байдаг бөгөөд ерөнхийдөө “Сурах гэдэг зүйлийг хүчилж болдоггүй ба харин өөрийн хүсэл эрмэлзлээрээ сурдаг” гэсэн утгатай.




The Central Library-Төв номын сан

Токивадай кампус дахь номын сан нь нийт 760,000 гаруй ном хэвлэлүүдтэй бөгөөд Ёкохамагийн Их сургуулийн хамгийн том номын сан юм. Номын сангийн нэг давхарт нь кафе байдаг.




Yaon-Yaon

Яаон гэдэг нь японоор гадаа концертийн талбай гэсэн үг юм. Өмнө нь энд усан оргилуур байдаг байсан боловч нураагаад оронд нь сургуулийн баяр наадмын үед ашиглах зорилгоор том тайз засдаг болсон. Энд өдрийн цайны цагаараа хоол идэж суух ч юмуу эсвэл ном уншиж суухад их тохиромжтой.



Economics Department Building Эдийн засгийн факультетийн байр

Энэхүү 8давхар өндөр барилга нь Олон улсын нийгмийн ухааны магистр болон докторын сургуулийн төв байр юм. Энд англи хэл дээр хичээлээ үздэг эдийн засаг болон хуулийн магистр ба докторын түвшний оюутнууд суралцдаг. Мөн түүнчлэн энд бие даах өрөө болон хичээлийн анги танхимаас гадна, оюутнуудад амарч тухлах эсвэл найз нөхөдтөйгөө хичээл судалгааныхаа талаар ярилцахад зориулсан өрөө хүртэл бий.



YNU monument-YNU хөшөө

Энэхүү 7 тонны жинтэй хөшөө нь Ёкохамагийн Их сургууль болон Вьетнамын Дананг Их сургуулийн хоорондын хамтын харилцааны бэлэг тэмдэг болгон Вьетнамаас Ёкохомагийн Их сургуульд илгээсэн бэлэг юм.